

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 дугаар тушаалын  
6 дугаар хавсралт

**ЭМЯ-НЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Л.ГЭРЭЛМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)			
<b>Зорилт 1. “Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”</b>								
1	Улсын байцаагчийн норматив, хяналт шалгалтын давтамжид нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах	Батлагдсан тушаал	ЭМС-ын 2023 оны А/79 дүгээр тушаал	Нэмэлт өөрчлөлт боловсруулж ЭМС-ын тушаалаар батлуулсан байна.	“Объектыг хяналт шалгалтад хамруулах давтамжийн хугацаа”, “Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив”, “Нэг объект шалгахад зарцуулах хугацааны норматив”, “Нэг объектын гүйцэтгэлийг шалгахад зарцуулах хугацааны норматив”-т тус тус нэмэлт өөрчлөлт оруулж боловсруулан, төслийг улсын байцаагчдын зөвлөгөөнөөр хэлэлцүүлж, саналыг тусган ЭМС-ын 2024.07.03-ны өдрийн А/309 дүгээр тушаалаар батлуулан аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлсэн.	03-09	100%	
2	4 төрлийн хяналтын хуудсыг шинэчлэх, 1 төрлийн хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулах	Батлагдсан хяналтын хуудасны тоо	ЭМС-ын 2023 оны А/78 дугаар тушаал	4 хяналтын хуудсыг шинэ чилж, 1 хяналтын хуудас шинээр боловсруулж батлуулсан байна.	Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй халдварт хамгааллын хяналтын чиглэлийн 4 төрлийн хяналтын хуудас (10.6.2 кодтой ЕБС-ын эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас, 10.6.3 кодтой ЕБС-ийн дотуур байрны эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас, 10.6.6 кодтой Хүүхдийн асрамж, халамжийн газрын эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах	01-03	100%	



					хяналтын хуудас, 10.6.7 кодтой Хүүхдийн зуслангийн эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас)-т 1 бүлэг, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалтад 155, хяналтын хуудасны асуултад 110, оноонд 47 нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, 1 хяналтын хуудас (10.6.10 кодтой Цэцэрлэг болон сургуулийн бага ангийн сурагчдын хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас) шинээр боловсруулж, аймаг, нийслэлийн улсын байцаагчдаас санал авч тусган ЭМС-ын 2024.02.22-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлуулсан. Батлагдсан хяналтын хуудсыг аймаг, нийслэлийн улсын байцаагчид, аж ахуйн нэгж, байгууллагад хүргэхээр ЭМЯ-ны сайтад байршуулж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.		
3	Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын чиглэлээрх хяналт шалгалтын дүнд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хийн хэрэгжилтийг судлан нэгтгэж, боловсронгуй болгох санал боловсруулах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	-	2023 оны хяналт шалгалтын дүнд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг гарган, холбогдох саналыг боловсруулж, нэгтгэлд хүргүүлсэн байна.	- Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй халдварт хамгааллын хяналтын чиглэлээр 2023 онд хийсэн төлөвлөгөөт төлөвлөгөөт бус, 5 төрлийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнгээр хууль тогтоомжийн хэрэгжилт 59.8 хувь, эрсдэл үүсэх магадлал 40.2 хувьтай байна. Хяналт шалгалтын дүнгээс үндэслэн 6 хуулийн 8 заалт, холбогдох сайдын тушаалаар батлагдсан 5 журам, Засгийн газрын 3 тогтоолоор батлагдсан журам, дүрэм, 6 стандартад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж нэгтгэлд тусгасан. - Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр 2023 онд хийсэн хяналт шалгалтын дүн, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, боловсронгуй болгох чиглэлээр 8 хуулийн 15 заалт, Засгийн	01-02	100%




					газрын тогтоолоор батлагдсан 2 журам, зааварт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 2/2219 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, 2023 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-уудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2024.04.25-ны өдрийн 1a/1711 дугаар албан бичгээр хүргүүлж, тус газраас 2024.05.29-ний өдрийн 01/471 дүгээр албан бичгээр хариу ирүүлсэн.	
--	--	--	--	--	---	--

**Зорилт 2. "Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ"**

4	Архангай, нийслэлийн БЗД, СБД-т зарлагдсан их, дунд эрс дэлтэй боловсролын сургалтын байгуулла гад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Объектын хамралтын хувь	-	100%	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн БЗД-ийн Пельханов ерөнхий боловсролын сургуульд хамтарсан төлөв лөгөөт хяналт шалгалт хийж, 10.6.2 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийн түвшинг үнэлэхэд 43.1 хувиар “Дунд” эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт 56.9 хувьтай байна. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар хугацаатай 12 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн, хэрэгжилт <b>63.6</b> хувьтай байна.</li> </ul>	02-10	88.9%
		Эрсдэлийн түвшин	Их-11%	Их-10.5%			
		Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	59.6%	60%	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн СБД-ийн Шинэ-Үе ерөнхий боловсролын сургуульд хамтарсан төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 10.6.2 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдварт хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийн түвшинг үнэлэхэд 31.3 хувиар “Дунд” эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн</li> </ul>		

150




					xэрэгжилт <b>67.0</b> хувьтай байна. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар хугацаатай 14 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлсэн, хэрэгжилтийн хугацаа болоогүй байна. /2025.03.01 - Архангай аймагт хяналт шалгалт иих удирдамжийн төслийг нэгтгэн боловсруулж, Салбарын ерөнхий байцаагчаар батлуулж төлөвлөсөн 7(11) объектыг 100 хувь хяналт шалгалтад хамруулсан. Боловсролын сургалтын байгууллагын шалгалтанд хамрагдсан 11 газраас 5 буюу 45 хувь нь их эрсдэлтэй, 6 буюу 55 хувь нь дунд эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт <b>52.4</b> хувьтай байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 61 заалттай улсын ахлах байцаагчийн 7 албан албан шаардлагыг хүргүүлсэн, хэрэгжилтийн хугацаа болоогүй байна. /2025.03.01 Хамтарсан хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга, албан шаардлага, холбогдох гаруудад үүрэг чиглэл хүргүүлэх албан бичгүүдийг нэгтгэн боловсруулж, аймгийн Засаг даргад 2024.10.18-ны 10-00-02/007/72 албан шаардлага, ЭМГ-т 2024.10.23-ны 9/4309, БГ-т 2024.10.23-ны 9/4308 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хамралт-100%, хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар <b>61.0</b> хувьтай байна.	
5	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах	Объектын хамралтын хувь	100%	100%	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан 2024.01.25-ны өдрийн 10-00/10 дугаартай батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн улсын хэмжээнд хийх хяналт шалгалтыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган зохион байгуулж, дүнг нэгтгэж танилцуулга боловсруулсан. Шалгалтад 12 аймгийн 16,	02-08
		Зөрчил арилгуу лалтын хувь	24.7%	25.0%		
		Хууль тогтоомжийн	67.5%	68.0%		

11



		хэрэгжилтийн хувь			нийслэлийн 12, нийт 28 хүүхдийн зуслан хамрагдахаас <b>100 хувь</b> хамрагдсан. Хяналт шалгалтын явцад нийт 178 зөрчил дутагдал илрүүлж, газар дээр нь <b>32.7</b> хувийг арилгуулж, 126 заалт бүхий улсын байцаагчийн 8 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Хяналт шалгалтаар 28 зуслангийн үйл ажиллагааг “Хүүхдийн зуслангийн эрүүл ахуй, халдварт хамгааллыг шалгах” 10.6.7 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 8 буюу 28.6 хувь нь бага, 17 буюу 60.7 хувь нь дунд, 3 буюу 10.7 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль тогтоомжийн хэрэгжилт <b>63.5</b> хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 4.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зуслангууд улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг, барилга байгууламж нь хуучирсан, санхүүжилт дутмаг, улс, орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэггүй, хүний нөөц дутагдалтай, тогтвортой бус, мөн удирдлагын зүгээс анхаарч ажилладаггүй, ажиллагдын үүрэг, хариуцлага сүл байгаагас зөрчил арилахгүй давтагдан гарах хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нөхцөл болж байна. Хяналт шалгалтын дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2024.10.24-ний өдрийн 9/4325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
6	Нялх, балчир, бага насны болон цэцэр лэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад	Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	100%	100%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан 2024.01.25-ны өдрийн 10-00/09 дугаартай батлуулж, аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн улсын хэмжээнд хийх хяналт шалгалтыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган зохион	01-12	100%



	зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэр лэл шинээр эрхлэгч дэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьд чилсан хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах				байгуулж, дунг нэгтгэж танилцуулга боловсруулсан. Нялх балчир, бага насы, цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулах 6 аймгийн 22, нийт улсын хэмжээнд 31 газраас хүсэлт ирүүлсний дагуу хяналт шалгалт хийж, давхардсан тоогоор нийт 116 зөрчил дутагдал илрүүлж, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод албан шаардлага хүргүүлж, 1 объектод гүйцэт гэлийн хяналт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн тул нийт 30 объектод улсын байцаагчийн дүгнэлт гаргаж, гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдаагүй дунд эрсдэлтэй 1 объектод дүгнэлт гаргаагүй байна. Хяналт шалгалтаар 31 сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн газ руудад 10.6.10 кодтой “Цэцэрлэг болон сургуулийн бага ангийн сурагчдын хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийх хяналтын хяналтын хуудас”-аар үнэлэхэд 29 буюу 93.5 хувь нь бага, 2 буюу 6.4 хувь нь дунд эрсдэлтэй үнэлэгдэж, гүйцэтгэлийн шалгалтаар 1 объектын эрсдэлийн түвшин буурч, хууль тогтоомжийн хэрэгжилт 86.4 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 7.6 хувиар дээшилсэн, эрсдэл үүсэх магадлал 13.7 хувьтай байна. Хүсэлтийн шийд вэрлэлт <b>100 хувьтай</b> байна.		
7	Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл	Хамруулсан объектын тоо Шаардлага	326/6 65.1%	Хүсэлтийг 100% шийдвэрлэсэн байна.	- Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын чиглэлээр улсын хэмжээнд боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг барих газрын байршил тогтооход хяналт хийг дээгүй, барилгын зураг төсөл зөвшилцөх	01-12	100%

25




	зохиох, барих, зориулалтыг өөрчлөх, ашиглалтад оруу лахад хийх эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалтыг зохион байгуулах	барилга өргөтгөх, хангасан хувь			<p>173, ашиглалтад оруулахад 33 нийт 206 объектын эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийсэн байна. Боловсролын сургалтын байгууллагын барилгын зураг төсөл зөвшилцөх чиглэлээр 173 объектод хяналт хийж, шаардлага хангасан 159 (91.9%) зураг төсөлд улсын байцаагчийн дүгнэлт гаргасан ба шаардлага хангаагүй 14 буюу 8.1 хувь байсан байна. Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг байнгын ашиг лалтад оруулах чиглэлээр нийт 33 объектод хяналт хийснээс 24 барилгыг ашиглалтад авах, 9 буюу 27.3 хувь нь норм дүрэм, стандартын шаардлага хангаагүй, үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй тул ашиглалтад хүлээн авахаас татгалзсан байна. Хяналт шалгалтын явцад нийт 120 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуу лахаар барилгын зураг төслийн чиглэлээр 16 албан бичиг, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисст ажилласан хүрээнд 25 үүрэг даалгавар өгч, зөрчил арилгасан 173 барилгын зураг төсөлд хяналт хийж, 159 дүгнэлт, 24 барилгыг байнгын ашиглалтад хүлээн авахыг зөвшөөрсөн байна.</p> <p>- ЭМЯ-нд ирүүлсэн 4 компанийн 2 аймгийн 7 сумын цэцэрлэг, ЕБС-ийн спорт заал, ариун цэврийн байгууламжийн нийт 8 барилгын зураг төсөлд хяналт хийн, улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн.</p> <p>- Салбарын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаанд нийт 60 барилгын зураг төслийг хянаж баталгаажуулсан.</p>	
--	---	---------------------------------------	--	--	--	--




8	Түрэсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэр лэг, ерөнхий боловс ролын сургуулийн орчны аюулгүй байдал, эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн нөх цөлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Объектын хамралтын хувь	-	60%	Tүрэсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулан Салбарын хяналтын газрын даргаар батлуулж, 2024.02.19-ний 03-00/02 дугаар тай удирдамжийг аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, нийслэлийн НД-т үйл ажиллагаа явуулж буй 1 сургууль, 1 цэцэрлэгт хамтарсан хяналт шалгалт хийсэн ба улсын хэмжээнд хийсэн шалгалтын дүнг нэгтгэж танилцуулга бичиж, удирдлагад танил цуулан хяналт шалгалтын дүнг 2024.07.03-ны өдрийн 2/2859 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хяналт шалгалтад нийслэлийн 7 дүүргийн төрийн өмчийн 102 цэцэрлэгийн салбар бүлэг, 6 аймгийн 15 цэцэрлэгийн салбар бүлэг, нийслэлийн 22 ерөнхий боловсролын сургуулийн салбар болон 6 аймгийн 10 сургууль, нийт 150 байгууллага хамрагдсан. Шалгалтад хамрагдсан 117 салбар цэцэр лэгийг 10.6.1 кодтой “Цэцэрлэгийн эрүүл ахуйн нөхцөл, халдварт хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийг үнэлэхэд 21 буюу 18% нь их, 86 буюу 73.5% нь дунд, 10 буюу 8.5% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль тогтоомжийн хэрэгжилт 59.7 хувьтай, ерөнхий боловсролын 32 сургуулийг 10.6.2 кодтой Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуйн нөхцөл, халдварт хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 12 буюу 37.5% нь их, 16 буюу 50% нь дунд, 4 буюу 12.5% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн ба хууль тогтоомжийн хэрэгжилт 50.9 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 526 зерчил	02-06	100%
		Зөрчил арилгуулалтын хувь	-	25%			
		Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	-	Хяналт шалгалтаар тогтоосон байна.			


185




					илрүүлж 32%-ийг газар дээр нь арилгуулж, хугацаатай үүрэг даалгавар ёгч 46 байгууллагад 269 заалттай албан шаардлага, 5 байгуул лагад зөвлөмж, 4 байгууллагад 2,000 мян. төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч барагдуулсан байна. Хамралт 100 хувьтай.		
9	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдла гаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэр лэлтийн хувь	100%	100%	<p>Хүүхэд, ёсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр улсын хэмжээнд 35 өргөдөл гомдол ирүүлсэнд 100 хувь хяналт шалгалт хийснээс 57.1 хувь нь үндэслэлтэй, 31.4 хувь нь үндэслэлгүй, 11.4 хувьд нь хяналт шалгалт хийгдэж байна. Өргөдөл, гомдол мэдээллийн мөрөөр хийгдсэн шалгалтын явцад нийт 6 зөвлөмж, 5 дүгнэлт, 35 заалттай 10 албан шаардлага, үйл ажиллагааг зогсоох 2 акт үйлдсэн байна. Зөрчлийн хэрэг 3-ыг нээж, хялбар шуулсан журмаар 1 ажиллагаа явуулж, 2 газрын үйл ажиллагааг хэсэгчилэн зогсоон, нийт 2500.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж барагдуулсан байна. Шалгалтын явцад үндны усны 2, хоолны 58, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 10, халдвар гүйтгэлийн бодисын 1, агаарын 14 дээж, эрүүл зүйн арчдас шинжилгээнд хамруулан, үнэлгээ дүгнэлт өгсөн байна.</p> <p>Ирүүлсэн өргөдөл, гомдлын 5.7 хувь нь сургуулийн дотоод орчны агаар бохирдолтой, 74.3 ххувь нь цэцэрлэг, сургуулийн хоол хүнс шаардлага хангахгүй, 2.9 хувь нь сургуулийн үндны ус шаардлага хангахгүй, 14.3 хувь нь сургалтын орчин нөхцөл шаардлага хангахгүй зөрчил эзэлж байна.</p>	01-12	100%
Зорилт 3. Улсын байцаагчдын чадавхийг сайжруулна.							



10	"2023 оны хяналт шалгалтын үр дүн, 2024 оны хяналт шалгалтын чиглэл" сэдэвт сургалт зохион байгуулах	Сургатын тайлан	2023 онд сургалт зохион байгуулсан	Сургалт зохион байгуулсан байна.	<p>Эрүүл мэндийн салбарын чиглэлээр 2023 онд хийсэн хяналт шалгалтын үр дүн, 2024 оны төлөвлөлт, анхаарах асуудал" сэдэвт сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр аймаг, нийслэлийн ЭМГ-ын улсын байцаагч нарт ЭМЯ-ны 306 дугаар өрөөнөөс цахим хэлбэрээр зохион байгуулсан.</p> <p>Сургалтад эмчилгээний чанарын хяналт, эрүүл ахуйн хяналтын чиглэл бүрээр 2023 онд хийсэн хяналт шалгалтын дүнгийн нэгтгэл дүн танилцуулга гаргахад тулгамдсан асуудал, шалгалтын нэгдсэн дүн, цаашид анхаарах асуудал, хяналт шалгалтын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлээгүй газруудын шалтгаан нөхцөлийг нэг бүрчлэн хяналтын чиглэл бүрээр улсын байцаагч нар мэдээлэл, ррт бэлтгэж танилцуулсан.</p> <p>Хяналт шалгалтын дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралд оруулж танилцуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргуулсан ба холбогдох яам, агентлаг газруудад албан бичгээр хүргүүлсэн талаар мэдээлэл өгсөн.</p> <p>Мөн 2024 онд хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын тогтоогоор баталсан "Хяналт шалгалтын төлөвлөгөө", түүнийг хэрэгжүүлэх арга зам, хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулсан мэдээлэл зэргийг танилцуулж, харилцан мэдээлэл солилцож нэг ойлголтод хүрсэн.</p> <p>Сургалтад аймаг, нийслэлийн ЭМГ-ын болон хяналт шалгалтын нэгжийн удирдлага, улсын байцаагчид оролцсон.</p> <p>Асуулт хариулт явуулж, урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтынг хэрхэн зохион байгуулж, зөрчил дутагдлыг газар</p>	02-03	100%
----	--	-----------------	------------------------------------	----------------------------------	--	-------	------



					дээр нь арилгуулж, эрсдэлгүй ажиллуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах талаар үүрэг чиглэл өглөө.		
11	ЕБС, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчил гээнд тавих шаардлага" стандартын хэрэгжилтийг хангах нь" сэдэвт сургалт зохион байгуулах	Сургалтын тайлан	2023 онд сургалт зохион байгуулсан	Сургалт зохион байгуулсан байна.	<p>- ХШЖ-ийн бэлтгэл ажлыг хангах сургалтын хүрээнд "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандарт" сэдвээр мэдээлэл хийж, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих талаар нэгдсэн ойлголт өгсөн.</p> <p>Сургалтад аймаг, нийслэлийн ЭМГ-ын хүүхэд, ёсвөр үеийн эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчид, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, хоол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж, иргэд нийт 174 хүн хамрагдсан.</p> <p>-“Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн менежмент” сургалтыг БЕГ-тай хамтран зохион байгуулж, мэдээлэл өгч ажилласан. Сургалтыг цахимаар нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгин хоол зүйч, тогооч наарт зохион байгуулсан.</p> <p>-“Нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэгдсэн цэстөлөвлөлт, арга зүй сургалт”-ыг нийслэлд танхимаар, аймгуудад цахимаар зохион байгуулгадаж, илтгэл тавьж мэдээлэл хийсэн. Сургалтад нийт танхимаар 143, цахимаар 96 сургууль, цэцэрлэгийн тогооч ажилтнууд хамрагдсан.</p>	09-10	100%




12	"Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг эрх лэхэд тавигдах шаардлага" сэдэвт сургалтыг зохион байгуулах	Сургалтын тайлан	2023 онд сургалт зохион байгуулсан	Сургалт зохион байгуулсан байна.	"Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах шаардлага" сэдэвт сургалтыг батлагдсан 2024 оны Салбарын хяналтын газрын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр ЭМЯ-ны 306 дугаар өрөөнд цахимаар зохион байгуулсан. Сургалтад Ховд, Дорнод, Хөвсгөл, Төв, Өмнөговь, Орхон, Баянхонгор, Увс, Хэнтий, Булган, Дархан-Уул, Дундговь, Дорноговь аймаг болон нийслэлийн ЭМГ-ын хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын болон ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар, аймаг, нийслэлийн ХХААГ-ын хүнсний чанар стандартын улсын байцаагчид болон тухайн аймгуудад зуслангийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, эмч, тогооч, ажилтнууд хамрагдсан. Сургалтаар батлагдсан хөтөлбөрийн дагуу ЭМЯ-ны Салбарын хяналтын газраас "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Ерөнхий шаардлага MNS 5633:2023 шинчлэгдсэн стандартыг хэрэгжүүлэх нь", 2023 онд хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийсэн. Асуулт хариулт явуулж, урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтынг хэрхэн зохион байгуулж, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, эрсдэлгүй ажиллуулах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн.	05-06	100%
	Дүн					98.5%	

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх | Шалгур

Гүйцэтгэлийн түвшин



	арга хэмжээ	үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
13	Эрдэм шинжилгээний илтгэл боловсруулж хэвлүүлэх	Хэвлүүл сэн илтгэлийн тоо	3	1	"Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны суралцагчдын хоолны чанар, илчлэг, шимт чанарыг судалсан дүн" илтгэлийг хамтран бичиж, Нийгмийн эрүүл мэнд шинжлэх ухааны сэтгүүлийн 2024 оны №1-д хэвлүүлсэн. Хуудас 24-29	03-09	100%
14	Мэргэжлийн чиглэлийн чадавхижуулах сургалтад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	12	1-ээс доошгүй	-БНСУ-д "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоо, хүний нөөцийг чадавхижуулах сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулан шим тэжээлийн боловсрол олгож буй туршлага судлах сургалт"-д 2024.05.26-06.04-ний хооронд оролцож, сертификат авсан. Уг асуудлын хүрээнд МҮ-д хийгдэж буй үйл ажиллагааны талаар 2024-2044 он хүртлэх цагалбараар танилцуулга бэлтгэж танилцуулсан. -“Стандартын суурь асуудал” М1 сургалтад 2024.02.14-15-ны өдрүүдэд сууж, шалгалт өгч МТСЛСТ 0248/24 дугаар бүхий гэрчилгээ авсан./өөрийн зардлаар -Баталгаажуулалтын мэргэшсэн шинжээчийн М2 сургалтад 2024.02.19-23-ны хооронд 5 хоног сууж, шалгалт өгч, МТСЛСТ 0273/24 гэрчилгээ авсан./өөрийн зардлаар	02-12	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
( Албан тушаал )



..... / Л.ГЭРЭЛМАА /  
( Нэр, гарын үсэг )

2024.12.02  
( Огноо )

dn

